

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 193


Улаанбаатар хот

### ┌ Журамд өөрчлөлт оруулах тухай ┐

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх заалт, Боловсролын ерөнхий хуулийн 24.1.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Журам батлах тухай" Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 104 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш, ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам"-ын 2.3.7 дахь заалтын "жирэмсний болон амаржсаны амралттай байсан хугацаа." гэснийг "жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхдээ асрах чөлөөтэй байсан эхний нэг жил (12 сар) хүртэлх хугацаа." гэж өөрчилсүгэй.

2. Мөн журмын 2.5 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

